



**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.06.05 № 118 ЦАГ-САГ/2013/СТА-ЗГСНТ

Г Зөрчил арилгуулах тухай Г

Засгийн газрын 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Засгийн газрын 2006 оны 185 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын зээлийг дотоодод дамжуулан зээлдүүлэх журам”-ын дагуу БНХАУ-ын Засгийн газрын 300.0 сая ам.долларын экспортын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд Мэдээлэл, шуудан харилцаа холбоо, технологийн газарт 2012 оноос эхлэн хэрэгжиж буй “Мэдээлэл, холбооны үндсэн сүлжээний өргөтгөл, шинэчлэл” төслийн хүрээнд 45,649.6 мянган ам.долларыг дамжуулан зээлдүүлэх төсөл хүчин төгөлдөр болж, 2012 онд төслийн санхүүжилтэд 9,276,784,647.32 төгрөг олгож дамжуулан зээлийн авлагаар бүртгэсэн боловч одоо болтол зээлийн гэрээ байгуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 7.1, 7.7, Засгийн газрын 2006 оны 185 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын зээлийг дотоодод дамжуулан зээлдүүлэх журам”-ын 3.2, 3.3, 3.4 дүгээр заалтуудыг зөрчсөн байна

“Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д “...алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэсэн заалтыг үндэслэн дараах Албан шаардлагыг өгч байна.

Дээр дурдсан төслийн санхүүжилтийн гэрээг Мэдээлэл, шуудан харилцаа холбоо, технологийн газартай яаралтай байгуулж, 2012 онд төслийн санхүүжилтэд олгосон 9,276,784,647.32 төгрөгийг тус газрын санхүүгийн тайланд тусгуулах, гэрээг байгуулах хүртэл хугацаанд төслийн санхүүжилтийг зогсоох арга хэмжээ авч, биелэлтийг 2013 оны 11 дүгээр сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Ч.Тавинжил, Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газрын дарга Т.Доржханд нарт даалгав

АХЛАХ АУДИТОР

Г.ЮРА

